

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 10 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-9 сар	/тоогоор/		
			Нэмэгдсэн	Хасагдсан	2011-10 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	152	10 ¹		162
3	Даатгалын төлөөлөгч	2080	18 ²	7 ³	2091
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	8			8
6	Актуарч	12			12
7	Бусад		4 ⁴		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 152 дугаар тушаалаар “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2 салбар, 10 дугаар сарын 6-ны өдрийн 158 дугаар тушаалаар “УБ даатгал” ХХК-д Дархан-Уул аймгийн Дархан сум, Дорнод аймгийн Хэрлэн сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Ховд аймгийн Жаргалант сум, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Увс аймгийн Улаангом суманд 8 салбар нээн ажиллуулахыг тус тус зөвшөөрсөн;

²Хорооны даргын 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 157 дугаар тушаалаар “Мөнх даатгал” ХХК-ийн 18 төлөөлөгчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

³Хорооны 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 270 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн 7 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

⁴Хорооны даргын 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 169 дүгээр тушаалаар “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн оноосон нэрийг “Гэр даатгал” ХХК болгон өөрчлөхийг, Хорооны 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 267 дугаар тогтоолоор “УБ даатгал” ХХК-д ачааны даатгал, барилга угсралтын даатгал, агаарын хөлгийн даатгал, санхүүгийн даатгалын хэлбэрээр тусгай зөвшөөрөл нэмж олгохыг, 268 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн

бүтэцдээ өөрчлөлт оруулахыг, 269 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг тус тус зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2011 оны 10 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 10 дугаар сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-10 сар	2011-10 сар
1	Даатгалын нийт хураамж	1,537,251,404.6	2,698,422,749.1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	364,750,707.2	1,045,795,486.3
3	Давхар даатгалд төлсөн хураамж	670,300,010.9	157,932,896.2
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	4,482	9,392
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	22,739,296,272.2	73,205,593,560.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	45,913,620.0	167,232,950.4

2011 оны 10 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,161.2 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 1,749.1 сая төгрөгөөр буурч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 681.0 сая төгрөгөөр, өмнөх сарынхаас 20.7 сая төгрөгөөр тус тус өссөн, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 512.4 сая төгрөгөөр, өмнөх сарынхаас 1,507.9 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ердийн даатгалын компаниудын олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 10 сарын байдлаар дараах графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:




Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-10 сар	2011-10 сар
1	Даатгалын нийт хураамж	17,387,131.0	44,199,687.0
2	Олгосон нийт нөхөн төлбөр	5,177,779.0	28,288,441.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж		10,586,963.2
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	6	43
	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	3	3
	-Байгууллагын хугацаат даатгалд	3	2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		34
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		2
	-Тэтгэврийн даатгалд		2
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	20,000,000.0	10,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	403,000.0	20,000,000.0

Урт хугацааны даатгалын компанийн 2011 оны 10 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны 10 дугаар сартай харьцуулбал даатгалын хураамжийн орлого 26.8 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 23.1 сая төгрөгөөр тус тус өсч, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн орлого 6.6 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 14.9 сая төгрөгөөр мөн өссөн үзүүлэлттэй байна.

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн төвлөрүүлсэн даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 10 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2011-8 сар	2011-9 сар	2011-10 сар
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	47,914,877.1	32,272,425.1	30,926,510.7
2	Даатгалын зуучлагчийн орлого	19,439,897.3	13,427,330.0	18,908,904.7
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	46	58	33
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1,980,957,007.0	3,855,417,989.0	6,420,350,000.0

2011 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 33 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 18.9 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	2011-8 сар	2011-9 сар	2011-10 сар
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	3,824,318.2	3,727,000.0	5,860,636.4
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	193	217	294
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	9,002,000.0	16,260,000.0	17,225,000.0

2011 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 294 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 5.9 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.